



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 01 сарын 11 өдөр

Дугаар А/36

Чойр

Өвөлжилт хүндэрсэн малчдад өвс,
тэжээл үнэгүй олгох тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1 дэх хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3, 32.1.8, аймгийн Онцгой комиссын 2024 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 01 дүгээр хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Өвөлжилтийн нөхцөл байдал хүндэрсэнтэй холбогдуулан зудын гамшгийн эрсдэлийг бууруулах зорилгоор өвөлжилт хүндэрсэн сумдын малчдад аймаг, сумдын аюулгүй нөөцөөс үнэгүй олгох өвс, тэжээлийн хэмжээ, хуваарийг нэгдүгээр, хяналт тавьж ажиллах ажлын хэсгийг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

2.Сумдад хуваарилагдсан өвс, тэжээлийг малчдад зохион байгуулалттайгаар олгох, 2024 оны аюулгүйн нөөцийг яаралтай нөхөн бүрдүүлж зудын гамшгийн хариу арга хэмжээний бэлтгэл бэлэн байдлыг хангаж ажиллахыг сумын Засаг дарга нарт үүрэг болгосугай.


3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч, Шуурхай штабын дарга (Б.Наранбаатар)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.БАТСУУРЬ

Аймгийн Засаг даргын 2024 оны 0.1
дүгээр сарын 11-ны өдрийн 4/36 дугаар
захирамжийн 4/36 дүгээр хавсралт



Үнэгүй олгох өвс, тэжээлийн хэмжээ

№	Өвс /боодол/		тэжээл /шуудай/	
	2023 он	2022 он	2023 он	2022 он
Аймгийн нөөц	1910	2300	314	1200
Сүмбэр сум	1820	=	720	=
Баянтал сум	750	=	=	=
Шивээговь сум	1000	=	100	=
Дүн	5480	2300	1134	1200

Өвс тэжээлийн хуваарилалт

№	малчин өрх	Өвс /боодол/	Тэжээл /шуудай/
Сүмбэр	569	3870	987
Баянтал	93	180	279
Шивээговь	116	160	248
дүн	778	4210	1,514

Аймгийн 2022 оны үлдэгдэл 2300 боодол өвс, 1200 шуудай тэжээл, 2023 оны аюулгүйн нөөцөөс 1910 өвс, тэжээл 314 шуудай тэжээлийг үнэ төлбөргүй олгох.

Аймгийн Засаг даргын 2024 оны 001
дүгээр сарын 11-ны өдрийн 1/3 дугаар
захирамжийн 2 дугаар хавсралт



АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн дарга:

Д.Содном

(Аймгийн Засаг даргын Тамгын газрын
дарга)

Гишүүд:

Т.Бат-Эрдэнэ

(Сүмбэр сумын Засаг дарга)

Б.Ганбаяр

(Баянтал сумын Засаг дарга)

Ч.Сугармаа (Шивээговь сумын Засаг
дарга)

Ц.Баярхүү

(Цагдаагийн хэлтсийн дарга,
цагдаагийн хурандаа)

Б.Баярсайхан

(Тагнуулын хэлтсийн дарга, хурандаа)

Э.Түвшинзаяа

(Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга)

Нарийн бичгийн дарга:

Г.Хонгор

(Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө
оруулалтын хэлтсийн дарга)